

**Дорнод аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн
төсөлд өгөх дүгнэлт, санал**

2016.12.02

Илтгэгч: Дорнод аймгийн
Аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Б.Болортуул

Эрхэм төлөөлөгчид өө.

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4 дэх зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн 2017 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлтийг ИТХ-ын төлөөлөгч та бүхэнд танилцуулж байна.

Төсвийн төсөлд санал дүгнэлт өгөхдөө Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн төсвийн төсөл нь Төсвийн тухай хуульд нийцэж буй эсэхийг гол шалгуур болгодог.

Төсвийн орлогын талаар:

Дорнод аймгийн 2017 оны төсвийн орлогыг 15648,4 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2016 оны тодотгосон төсвөөс 540,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэр төрлөөр нь авч үзвэл татварын орлогыг 774,3 сая төгрөгөөр өсгөж, татварын бус орлогыг 233,8 сая төгрөгөөр бууруулсан байна. Татварын орлогын өсөлтийн 80 гаруй хувь нь цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос авах татварын орлого байна. Үүнийг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай холбоотой цалингийн орлогын өсөлтөд үндэслэн бодитой тооцсон гэж үзлээ. Харин газрын дуудлага худалдааны орлогыг 1094,5 сая төгрөгөөр тооцсоныг 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Сумдын хэмжээнд газрын дуудлага худалдаанаас 2015 онд 1040,5 сая төгрөг, 2016 онд 816,7 сая төгрөгийн орлого орсон байна. Сумдад төсөв хуваарилахдаа уг орлогыг төлөвлөн батлаагүйгээс орсон тухай бүрд нь төсөвтөө тодотгол хийн зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн төсөвт тодотгол хийх тухай 34.2, нэмэлт төсөв зарцуулах тухай 47.1 дэх заалтууд болон 5.1.3 дахь санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчимд нийцэхгүй байгаа юм.

Иймд аймгийн төвд зохион байгуулагдах газрын дуудлага худалдаанаас орохоор төлөвлөсөн 1094,5 сая төгрөгийн орлого дээр сумдын газрын дуудлага худалдаанаас 400,0 сая төгрөгийн орлогыг нэмж төлөвлөх саналтай байна.

Төсвийн зарлагын талаар:

2016.12.02

Төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах талаар дараах саналыг оруулж байна.

1. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 7.2-т төсвийг Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулахаар заасан. Төсвийн тухай хуулийн 33.2.11 дэх “төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар танилцуулгыг” төсвийн төсөлд тусгах тухай заалтыг хангахгүй нийт 35,0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-гаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн Матад суманд амаржсан эхийн байр барих 15,0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь зураг төсөвгүй байна.
- Аймгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, арга хэмжээнээс аялал жуулчлал, үйлчилгээний болон эрдэс баялгийн салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны зардалд 20,0 сая төгрөгийг тусгасныг бодлого хариуцсан хэлтсээс тодруулахад тодорхой мэдээлэлгүй байна.

Эдгээр нь төсөв зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байгаа тул дээрх 35,0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хасаж хуульд нийцсэн төсөл, арга хэмжээг нэмж оруулах саналтай байна.

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээг баримтлах ёстой. Аймгийн 2017 оны төсвийн төсөлд уг сангийн эх үүсвэрийг 841,5 сая төгрөгөөр төлөвлөсөн нь хуульд заасан хувь хэмжээнээс 221,6 сая төгрөгөөр бага байгааг нэмэгдүүлэх саналтай байна.

Аймгийн Аудитын газраас Дорнод аймгийн 2017 оны төсвийн орлогыг 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 256.6 сая төгрөгийн зарлагын үр ашгийг сайжруулах дүгнэлт саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.